

13.0 Төгсөлтийн үйл ажиллагаа

Төгсөлтийн үйл ажиллагаа

ЕБС -ийн төгсөх ангиудын хувьд дараах алхмын дагуу бүртгэл хийж төгсөлтийг баталгаажуулна.



Төгсөлтийн бүртгэлийн явцыг Сургалтын менежер дараах хянах самбарын тусламжтай харж болно.



13.1 Хянах самбар

Хянах самбар - Сургалтын менежер:

Хянах самбар нь 6 үндсэн чиглэлийн дагуу гүйцэтгэлийг харуулах хэсгийг хэлнэ. Үүнд:


1. **Хичээлийн дүн** - Заавал судлах хичээлийн хувьд харуулна.
2. **Судлагдахууны дүн** – Заавар судлах судлагдахууны хувьд харуулна.
3. **Шалгалтын дүн** – Шалгалтын дүн баталгаажуулалтын хувьд харуулна.
4. **Төгсөлтийн бүртгэл** - Төгсөлт баталгаажуулсан суралцагчдын хувьд харуулна.
5. **Баримт бичиг олголт** – Баримт бичиг хуваарилагдсан суралцагчдын хувьд харуулна.
6. **Элсэлтийн бүртгэл -** Дараагийн түвшинд суралцах, сургуулиас гарах шийдвэрийн хувьд харуулна.

Хянах самбар харахдаа дараах дарааллыг баримтална.

Боловсролын удирдлагийн **төгсөлт** модульд орно.


Сургалтын хөтөлбөр, **анги**, **бүлэг** сонгоно.

Дэлгэцийн зүүн талд байрлах жагсаалтаас **хянах самбар** гэсэн хэсгийг сонгоно.



13.2 Төгсөлт - Хичээлийн дүн баталгаажуулалт

Сургалтын менежер хичээлийн дүн баталгаажуулалт



- Цахим журнал ашигладаг:
  - Хичээл заадаг багш нь жилийн эцсийн дүнг системд бүртгэж баталгаажуулна.
  - Ангийн багш нь хичээл заадаг багшийн цахим журнал дээр бүртгэсэн дүнг шууд татан авч ашиглана.
- Цахим журнал ашигладаггүй:
  - Анги удирдсан багш нь суралцагч бүрийн жилийн эцсийн дүнг бүртгэнэ.

Төгсөлтийн бүртгэлийн “Хичээлийн дүн” хэсэгт баталгаажуулалт хийнэ.

Уг төгсөлтийн бүртгэлийн "Хичээлийн дүн"- гийн баталгаажилт нь

Бага боловсрол ---------- 5-р ангийн дүнг


Суурь боловсрол ----------9-р ангийн дүнг

Бүрэн дунд боловсрол----------12-р ангийн дүнг баталжуулалт хийнэ.

Сургалтын менежер зөвхөн “Хянагдаж байгаа” төлөвтэй дүнг хянаж, баталгаажуулж, цуцлах боломжтой.

Аль анги, бүлгийн хичээлийн дүнг хянах гэж байгааг “Хөтөлбөр” “Анги” “Бүлэг” сонгож “Баталгаажилт” ийг дарснаар баталгаажуулах үйлдэл хийх цонх гарч ирнэ.

1. Хичээлийн дүн дарж сонгоно.
2. Аль анги бүлгийн баталгаажилт хийх гэж байгааг сонгоно.
3. Хичээл баталгаажуулалтын үйлдэл хийх цонх руу шилжнэ.



4. Тухайн бүлгийн аль ангийн ямар төрлийн хичээлийн дүнг батлах гэж байгааг сонгоно.
5. Аль хичээл гэдгийг сонгоно. Хөтөлбөрийн дагуу заавал хичээл бол заавал төрөлтэй хичээл дотор байгаа. Сонгон хичээл бол сонгон судлах хичээлийг сонгоно.

-Гүнзгий хичээл бол сонгох судлах төрлийг сонгоно.

6. Бүх суралцагчийг сонгох боломжтой. Зөвхөн нэг суралцагчийн хичээлийн дүнг баталгаажуулах бол тухайн суралцагчийн нэрийн урд талыг сонгож баталгаажуулна.

13.3 Судлагдахууны дүн

13.4 Шалгалтын нэгтгэл

Шалгалтын нэгтгэл - Сургалтын менежер


Энэ хичээлийн жил онцлог жил учир дэвших шалгалт авахгүйгээр тухайн суралцагчын судалсан заавал болон сонгон судлах хичээлийн үнэлгээг анги удирдсан багш нь шалгалтын үнэлгээ хэсэгт бүртгэгдэх хичээлийг сонгож шалгалтын хэсэгт дүнг нь татан оруулсан.

Гэхдээ төгсөх анги учир шалгалтын үнэлгээ нь 3 удаагийн баталгаажуулах үйлдэл хийгсэн тохиолдолд батлагдсан гэх төлөвтэй болно.

Шалтгалтын нэгтгэлийг харахдаа дараах дарааллыг баримтална.


Төгсөлт модульд орж дэлгэцийн зүүн гар талд байрлах үндсэн цонхнуудаас **шалгалт** гэсэн цонх дээр дарна.

Түүний дараа нээгдсэн цонхны дээр байрлах хэсгээс шалгалтын нэгтгэл шалгах ангийн **сургалтын хөтөлбөр, анги, бүлэг** сонгоно.



Сонгогдсон ангийн суралцагчдын авсан үнэлгээ нь жагсаалтаар харагдана.


Мөн дэлгэцийн зүүн гар талд байрлах үндсэн цонхны ард байрлах тоо нь тухайн ангийн бүртгэгдэх ёстой /батлагдах шаардлагатай/ үнэлгээ болон бүртгэгдсэн /батлагдсан/ үнэлгээний тоог илэрхийлнэ.



13.5 Төгсөлтийн бүртгэл


ТӨГСӨЛТИЙН БҮРТГЭЛ

5-р ангийн төгсөлтийн бүртгэлийг сургалтын менежер баталгаажуулах эсвэл цуцалж болно.




Бүртгэлийн явцаас хамаарч 5-р ангийн төгсөлтийн бүртэлийн төлөв нь дараах байдлаар өөрчлөгдөнө.

№	Үйл ажиллагаа	Төлөв
1	АУБ төгсөлтийн бүртгэл хийгээгүй.	Бүртгээгүй
2	АУБ төгсөлт бүртгэсэн.	Бүртгэсэн
3	АУБ төгсөлтийн бүртгэлийг Менежерт илгээсэн.	Илгээсэн
4	Менежер төгсөлтийн бүртгэлийг Баталгаажуулсан. Баталгаажуулах	Батлагдсан
5	Менежер төгсөлтийн бүртгэл цуцалсан.	Цуцлагдсан



1. Төгсөлт баталгаажуулах, эсвэл цуцлах суралцагчийг сонгоно.
2. "Баталгаажуулах хүсэлт" товч дээр дарахад "илгээгдсэн" хүсэлтийг "хянагдаж байгаа" төлөвт шилжүүлнэ.
3. "Баталгаажуулах" товч дээр дарахад "илгээсэн" болон "хянагдаж байгаа" хүсэлтийг "Батлагдсан" төлөвт шилжүүлнэ.
4. "Цуцлах" товч дээр дарахад хүсэлтийг "цуцлагдсан" төлөвт шилжүүлнэ.

9, 12-р анги төгсөгчдийн хувьд дараах дарааллын дагуу бүртгэлийг хөтөлж, баталгаажилт хийнэ.



Бүртгэлийн явцаас хамаарч төлөв нь дараах байдлаар өөрчлөгдөнө.

№	Үйл ажиллагаа	Төлөв
1	АУБ төгсөлтийн бүртгэл хийгээгүй.	Бүртгээгүй
2	АУБ төгсөлт бүртгэсэн.	Бүртгэсэн
3	АУБ төгсөлтийн бүртгэлийг Менежерт илгээсэн.	Илгээсэн
4	Менежер төгсөлтийн бүртгэлийг БСУГ/БХ –д илгээсэн.	Хянагдаж байгаа
5	БСУГ/БХ –ийн мэргэжилтэн төгсөлтийн бүртгэлийг хянасан.	Хянагдсан
6	БСУГ/БХ –ийн Дарга төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулсан. БҮ/БГ дугаар болон QR код олгогдоно.	Батлагдсан
7	Төгсөлтийн бүртгэл цуцлагдсан.	Цуцлагдсан

Сургууль дээрээс баталгаажуулах хүсэлт илгээхэд анхаарах зүйлс

- “Бүртгэлийн маягт” хянана.
- Суралцагч бүрээр төгсөлтийг баталгаажуулна.
- Сургуулиас дүүргийн БХ –т “Төгсөлт баталгаажуулах хүсэлт” илгээсэн үед дараах бүртгэлүүд засварлах боломжгүй болно.
    - Хичээлийн дүн
    - Судлагдахууны дүн

13.6 Боловсролын баримт бичиг хэвлэх


Боловсролын баримт бичиг хэвлэх – Сургалтын менежер

Сургалтын менежер төгсөлтийн бүртгэл хэсгээс төгсөгчдөд боловсролын баримт бичгийг хэвлэн олгоно.

Жич: Анги удирдсан багш гэрчилгээ, үнэмлэх хэвлэхгүй.

Гэрчилгээ, үнэмлэхийг зөвхөн **Firefox** вэб хөтөч ашиглан хэвлэнэ.






Төгсөлт нь батлагдсан суралцагчид боловсролын баримт бичиг хэвлэн олгоно. Хэвлэн олгохоос өмнө үнэт цаасны дугаарыг Сургалтын менежер нь анги бүлгүүдэд хуваарилсан байх шаардлагатай.

1. БСУГ/БГ дээр төгсөлтийн бүртгэл батлагдахад Бүрэн дунд боловсролын үнэмлэхний дугаар /Ж: БҮ20205300001/, боловсролын баримт бичгийн баталгаажилтын QR код автоматаар олгогдоно.


Дугаар олгох товч дээр дарж боловсролын баримт бичиг хэвлэх үнэт цаасны дугаарыг сонгож хадгална. Хэрэв үнэт цаасны дугаарыг буруу сонгосон бол 220000029 Дугаар олгох товч дээр дарж өөр дугаараар сольж болно.




Хэвлэх

товч дээр дарж боловсролын баримт бичгийг хэвлэх цонх руу шилжинэ.

Хэвлэх цонхны харагдах байдал.



Боловсролын баримт бичиг хэвлэх цонхны  товчийг ашиглан ноорог байдлаар боловсролын баримт бичгийг хэвлэн үзэж сургуулийн албан ёсны нэр, суралцагчийн овог нэр, дүн үнэлгээ, монгол бичгээр зөв бичигдсэн эсэхийн хяналтыг хийнэ.

13.7 Элсэлтийн бүртгэл

13.7 Элсэлтийн бүртгэл

Энэхүү үйл ажиллагаа нь 5,9,12-р ангиуд төгсөлт хийж байгаатай холбоотой бөгөөд дараагийн хичээлийн жилд ямар анги бүлэгт суралцахыг илэрхийлнэ.

Энэхүү үйлдлийг анги удирдсан багш нар хүсэлт илгээсэн тохиолдолд сургалтын менежер шийдвэрлэнэ.

1. **Төгсөлт** үйл ажиллагааг сонгоно.

2. **Элсэлтийн бүртгэл** цонхыг нээнэ.

3. **Баталгаажуулах** болон **цуцлах** үйлдэл хийнэ.

Элсэлтийн бүртгэлийг баталгаажуулахдаа дараах дарааллыг баримтлана.


Төгсөлт модульд орж дэлгэцийн зүүн гар талд байрлах үндсэн цонхнуудаас **элсэлтийн бүртгэл** гэсэн цонх дээр дарна.

Түүний дараа нээгдсэн цонхны дээр байрлах хэсгээс элсэлтийн бүртгэл шийдвэрлэх ангийн мэдээллийг сонгоно.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/138, А/262, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/52, 2019 оны А/336, 2020 оны А/308, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны А/221, А/267, А/352, А/383, 2022 оны А/84 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л. ЭНХ-АМГАЛАН

Уг сонголтыг хийхэд ангийн суралцагчдын мэдээлэл харагдах бөгөөд дэлгэцийн баруун дээд хэсэгт байрлах баталгаажуулах болон цуцлах үйлдэл хийж шийдвэрлэнэ.



13.8 Нэр залруулсан зарчим - Монгол бичиг

Нэрийн залруулгын тухай

2021-2022 оны хичээлийн жилд төгсөх ангийн суралцагчдын овог, нэрийг жигдлэх ажлыг МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн дэргэд байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулсан. Төгсөгчдийн овог нэрийг жигдлэхэд баримталсан зарчмыг ажлын хэсгээс ирүүлсэн тул үүгээр хүргүүлж байна. Энэхүү зарчмын дагуу монгол бичигт хөрвүүлсэн төгсөгчдийн нэрс боловсролын баримт бичигт бичигдэнэ. Зайлшгүй тодруулах зүйл гарвал 80039991 дугаарт холбогдоно уу.

Нэр хөрвүүлсэн зарчимтай дараах холбоосоор дамжин танилцана уу.

Боловсролын баримт бичгийг хэвлэхдээ зөвхөн **MOZILLA FIREFOX** браузер ашиглан хэвлэхийг анхааруулъя!

Төгсөгчдийн нэр хөрвүүлсэн зарчим

Хичээлийн нэр хөрвүүлсэн зарчим
